

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 6 дүүгэр
сарын 25-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах, Ажлын албаны
бүтцийн схем, орон тоог батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18.1, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтцийн схем, орон тоог 90 хүнээр баталсугай.
2. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны “Хорооны Ажлын албаны бүтэц, тэдгээрийн чиг үүрэг батлах тухай” 46 дугаар тогтоолын Нэг дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 7, 8 дахь заалт нэмсүгэй:

1/ “7. Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газар,
8. Дотоод хяналтын алба”.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 46 дугаар тогтоолын “Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг”-ийг баталсан хавсралтад дор дурдсан агуулгатай 9, 10 дахь хэсэг нэмсүгэй:

1/ “**Ес. Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газар**

Хорооны зохицуулалтын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлагнал, олон нийтэд хүргэх мэдээллийн үнэн зөв, бодитой байдал, аудит, үнэлгээний үйл ажиллагааны чанарт хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн чиг үүргийг нэгтгэн гүйцэтгэнэ. Үүнд:

9.1. Зохицуулалтын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд шинжилгээ хийх замаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн, санхүүгийн тайлагналыг хууль тогтоомжийн дагуу олон нийтэд хүргэх үйл ажиллагаанд хяналт тавих,

9.2. Зохицуулалтын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлантай холбоотойгоор хийгдсэн аудитын болон үнэлгээний байгууллагуудын дүгнэлт, үнэлгээнд чанарын хяналт тавих,

9.3. НББ, аудит, үнэлгээний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулж, олон улсын холбогдох стандартуудыг зохицуулалтын хүрээний байгууллагуудад нэвтрүүлэх,

9.4. Хороог үнэн бодит мэдээллээр хангаж, гаргах шийдвэрийн үндэслэлийг боловсруулах,

9.5. Зохицуулалтын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд тусгай хуваарийн дагуу түүвэрчилсэн шинжилгээ хийнэ,

9.6. НББ-ийн хууль, эрх зүйн актуудын хэрэгжилтийг зохицуулалтын хүрээний байгууллагуудаар хангуулах ажлыг удирдан зохион байгуулна,

9.7. Санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад ашиглагдаж буй НББ-ийн программ хангамжийг боловсронгуй болгох санал, санхүүгийн тайлагналын стандарт маягт, загвар боловсруулж, нэвтрүүлнэ,

9.8. Зохицуулалтын хүрээний байгууллагууд санхүүгийн байдлынхаа талаар олон нийт, сонирхогч талуудад үнэн зөв, хуулийн дагуу тайлагнаж байгаа эсэхэд хяналт тавина,

9.9. Зохицуулалтын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, хөрөнгийг үнэлсэн үнэлгээний чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудит, үнэлгээний ажлын мэдээллийн сан байгуулна,

9.10. Аудиторч, үнэлгээчдийн ёс зүйн хэм хэжээг сахиулах, ёс зүйн шинэ шаардлагуудыг боловсруулан мөрдүүлэх талаар аудит, үнэлгээний компаниуд, холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллана,

9.11. НББ, аудит, үнэлгээний үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, олон улсын холбогдох стандартуудыг зохицуулалтын хүрээний байгууллагуудад нэвтрүүлэх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана,

9.12. Аудит, үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой гадаад орнуудын практик туршлагыг судалж, санхүүгийн салбарт нэвтрүүлэх арга хэмжээнүүдийг авна,

9.13. Санхүүгийн болон аудит, үнэлгээний байгууллагуудын ажилтнуудад санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний үйл ажиллагаатай холбоотой асуудлаар сургалт зохион байгуулж, мэргэшлийн, арга зүйн зөвлөгөөгөөр хангана,

9.14. Шаардлагатай гэж үзвэл Хорооноос гаргах шийдвэрийн санхүүгийн тайлан, аудит, үнэлгээний асуудалтай холбоотой үндэслэлийг боловсруулж, өндөр мэргэшлийн зөвлөгөөгөөр хангана,

9.15. Хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр зохицуулалтын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргах асуудлыг хариуцна,

Арав. Дотоод хяналтын алба

Дотоод хяналтын алба нь Хорооны даргын шууд удирдлага дор ажиллаж, дараах чиг үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

10.1. Хорооны тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах,

10.2. СЗХ-ны үйл ажиллагааны хэтийн болон жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавих,

10.3. Ажлын албаны зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, ажлын гүйцэтгэлийг шалгах,

10.4. СЗХ-ны төсвийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааг шалган, илэрсэн зөрчлийг арилгуулах,

10.5. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын дагуу өгсөн хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэх, цаашид авах арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргах,

10.6. СЗХ-ны дотоод хяналтын систем, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд удирдлагад туслалцаа үзүүлэх

4. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 46 дугаар тогтоолын “Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтэц”-ийг баталсан хавсралтыг хүчингүйд тооцсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН